



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/212

Арвайхээр

┌ Бизнес инкубатор төв байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.д, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 30 дугаар зүйлийн 30.3.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 5.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэд “Бизнес инкубатор төв”-ийг байгуулсугай.

2. “Бизнес инкубатор төвийн ажиллах дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.


3. Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулж, төвийн үйл ажиллагааны тайланг жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100460



БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.“Бизнес инкубатор төв”-ийн /цаашид БИТ гэх/ дүрэм нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогод нийцүүлэн төвийн үйл ажиллагааны зорилго, чиг үүрэг, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР. БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙН ЗОРИЛГО

2.1.БИТ-ийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүссэн иргэнд /цаашид бойжигч гэх/ бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний бизнес санааг хөгжүүлэх, бизнесийн үйл ажиллагааг нь бойжуулах, бие даан аж ахуй эрхлэх чадвар бий болгоход оршино.

ГУРАВ. БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1.БИТ нь сургах, зөвлөх, ур чадваржуулах, бүтээгдэхүүн борлуулалтад дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн 4 чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд доорх үйл ажиллагааг зохион байгуулна.

- 3.1.1 Бойжигчдод хувь хүний хөгжлийн болон хууль эрх зүй, санхүү, аж ахуй эрхлэлт, маркетинг, менежмент, техник, технологийн ерөнхий мэдлэг олгох сургалтыг багц хөтөлбөрөөр зохион байгуулна.
- 3.1.2 Бойжигч бүрийн бизнесийн санааг үнэлэх замаар тэдний хэрэгцээнд үндэслэсэн төлөвлөгөөт сургалт, мэдээлэл өгөх, зөвлөх үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулна.
- 3.1.3 Бойжигчид мэргэжил олгох, чадамж эзэмшүүлэх, мэргэжлийн түвшин тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулна.
- 3.1.4 Бойжигч бүрт зах зээлийн судалгаа хийх, бүтээгдэхүүн сурталчилах, борлуулалтын сүлжээ байгуулах, бизнес түншлэлийн харилцаа тогтооход нь дэмжлэг үзүүлж ажиллана.
- 3.1.5 Бойжигчийн бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх, ажлын байрыг тогтвортой хадгалах, нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулна.

3.2.БИТ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах ажлыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан зохион байгуулна.

ДӨРӨВ. БИЗНЕС ИНКУБАТОР ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ

4.1.БИТ нь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын байранд байрлах ба бойжигчдын ажлын байрны ашиглалтын зардал, урсгал засварыг тус газар хариуцана.

4.2.Энэхүү журмын 3.1.1, 3.1.2, 3.1.4-т заасан үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ба бойжигч нь сургалт, мэдээлэл, зөвлөгөө авах зардлаа хариуцана. Зардал нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишиг хэмжээгээр байна.

4.3.Энэхүү журмын 3.1.1, 3.1.2, 3.1.4-т заасан үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ба төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах, хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар зохион байгуулна.

4.4.Бойжигчдын аж ахуй эхлэлтийн сургалт, гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцох, борлуулалтын дэмжлэг үзүүлэх зэрэг зарим үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон холбогдох дүрэм журмын дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зохион байгуулна.

ТАВ. БОЙЖИГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, БОЙЖИГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1.Бойжигч нь бизнес инкубацийн үйлчилгээнд 2 жилийн хугацаанд хамрагдана.

5.2. Бойжигч сонгон шалгаруулах ажлын хэсгийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаалаар томилж, сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулна. Ажлын хэсэгт ажил олгогч, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг заавал оруулсан байна.

5.3. Бойжигч сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь үнэлэх, сонгох гэсэн 2 үе шаттай байна.

5.4. Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргагч иргэнийг сонгох үндсэн шалгуур нь түүний бизнесийн санаа байна. Бизнесийн санаа нь төслийн хэлбэрээр бичигдсэн байна. Хүсэлт гаргагч иргэнийг доорх 4 бүлэгт ангилж сонгоно.

5.4.1. Хувиараа хөдөлмөр эрхлэх болон аж ахуй эрхлэх сонирхолтой ажилгүй иргэн

5.4.2. Хувийн бизнесээ эхлүүлсэн иргэн

5.4.3. Үйл ажиллагаагаа эхлүүлээд удаагүй байгаа бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч

5.4.4. Үүсэн байгуулагдаад удаагүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгч

5.5.Энэхүү журмын 5.4.1, 5.4.2-т заасан иргэний бизнесийн санааг үнэлэхдээ тухайн төслийн зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ, зохион байгуулалт (хүний нөөц, материаллаг нөөц, эдийн засгийн нөөц)-ийг үнэлнэ.

5.6.Энэхүү журмын 5.4.3, 5.4.4-т заасан иргэний бизнесийн санааг үнэлэхдээ 5.5-т заасан үнэлгээн дээр нэмж аж ахуй эрхлэгчийн шинж төрх, төлөвлөж буй бизнесийн нийгмийн ач холбогдол, бүс нутгийн болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, жендэрийн асуудлыг үнэлнэ.

5.7. Үнэлгээ нь “сайн” (90-100), “хангалттай” (60-89), “дунд зэрэг” (40 хүртэл), “хангалтгүй” (0-30) гэсэн үнэлгээтэй байна. Үнэлгээний ерөнхий дүнг гаргахдаа асуумж бүрийн үнэлгээний арифметик дунджаар тооцно. Үнэлгээг өсөх дарааллаар эрэмбэлж хамгийн өндөр үнэлгээтэй хүсэлт гаргагч иргэнийг бойжигчоор сонгоно.

5.8. Үнэлгээний асуумжийг Монголын бизнес инкубаторуудын нэгдсэн холбооны гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж буй асуумжийг жишиг үндэслэл болгож, орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийн бодлогод нийцүүлэн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг боловсруулна.

5.9. Бизнес инкубацийн үйлчилгээнд хамрагдахаар шалгарсан иргэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг чадавхижуулах, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоход дэмжлэг үзүүлэх, гарааны бизнесийг дэмжих, үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулахад чиглэсэн ажил үйлчилгээг тухайн жилд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн зорилт арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан зохион байгуулна.

6.2. Энэхүү журамд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, талуудын хооронд гарсан маргааны шийдвэрлэх зэрэг асуудлыг Монгол улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид зааснаар гүйцэтгэнэ.